МЭДЭЭ · 2020 оны 6-р сарын 16

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛ АВСАН ИРГЭН ДАХИН ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС ХЭРЭГЛЭЖЭЭ



Баянгол дүүргийн прокурорын газрын ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсээс шүүхээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэхийг хязгаарлах албадлагын арга хэмжээ авагдсан 15 хүнд 2020 оны 6 дугаар сарын 03-ны өдөр сургалт зохион байгууллаа.

Энэ үеэр мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг тус дүүргий Цагдаагийн 1 дүгээр хэлтэстэй хамтран шалгахад 1 хүнээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илэрсэн тул дүгнэлт гаргуулахаар Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргүүлсэн байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3161